



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Цогц арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.5.10.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Үндэстний үнэлэмж” гадаад сурталчилгааны цогц арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Уг цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг Гадаад харилцааны яамны жил бүрийн төсөвт суулган батлуулж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаярт даалгасугай.

3. “Монгол Үндэстний үнэлэмж” гадаад сурталчилгааны цогц арга хэмжээний хэрэгжилтийг жилд 2 удаа тайлагнаж байхыг Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сэрээжавт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ



**“МОНГОЛ ҮНДЭСНИЙ ҮНЭЛЭМЖ”
ГАДААД СУРТАЛЧИЛГААНЫ ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж, хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”, 3.1.4.6-д “Дэлхийн бусад орон, түүний дотор гуравдагч хөрш орнуудтай соёлын салбарт өргөн харилцаа хөгжүүлж, дипломат төлөөлөл, иргэдээрээ дамжуулан монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах ажлыг эрчимжүүлнэ”,

2. УИХ-ын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалын 24-т “Соёл хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын зорилго нь үндэсний соёл иргэншил, өвөрмөц өв уламжлалаа дэлхийн соёлын нийтлэг ололттой хослуулан хөгжүүлэх, түүх, соёлын үнэт зүйлээ хамгаалах, сэргээх, түүхэн шалтгаанаар гадаадад гарсан эд өлгийн зүйлийг сурвалжлан олоход чиглэсэн хамтын ажиллагаа хөгжүүлэх, нийгэм, хүмүүнлэгийн салбарын шууд харилцаанд тус дөхөм үзүүлэх явдал мөн”, 29.1-д “Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад сурталчлах үйл ажиллагааг идэвхижүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих”, 29.2-т “Монголын түүх, байгаль, зан заншил, ахуй амьдрал, хөгжил дэвшлийг харуулсан сурталчилгааны ном товхимол, нэвтрүүлэг, кино, цомог зэргийг бэлтгэн бусад улс түмэнд түгээх, сурталчлах”, 29.7-д “гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлэхэд ардын болон соёлын дипломатын арга хэлбэрийг хэрэглэх” гэж,

3. УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын 2.1.4. дэх зорилт нь “Үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах” гэж,

4. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5 дахь зорилт нь “Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө” гэж,

5. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.10-д “Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад

сурталчлах, таниулах “Монгол Үндэстний үнэлэмж” арга хэмжээг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлэх” гэж тус тус заасан нь энэхүү цогц арга хэмжээг батлан хэрэгжүүлэх үндэслэл болно. Энэхүү цогц арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн үргэлжлэл юм.

Хоёр. Зорилго, зорилт

2.1 Цогц арга хэмжээний зорилго нь Монгол Улсын түүх, зан заншил, соёл урлаг, өв уламжлалыг олон улсад сурталчлах, таниулахад оршиж байгаа бөгөөд гадаад сурталчилгаа, соёлын харилцаа, хамтын ажиллагааны нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгох, өв соёлоороо дамжуулан Монгол Улсын нэр хүндийг олон улсад дээшлүүлэх, үндэсний хөгжлийн гадаад таатай орчныг бүрдүүлэх, сайжруулах, хилийн чанад дахь монгол соёлын өвийг олж тогтоох, хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэнэ.

2.2 Цогц арга хэмжээний хүрээнд дараах зорилтыг дэвшүүлнэ:

2.2.1. Монгол үндэстний үнэт зүйлс, Монгол Улсын түүх, биет болон биет бус соёлын өв, уламжлалт болон орчин үеийн соёл, урлаг, оюуны болон дижитал бүтээл, спортын амжилтыг дэлхийн хэмжээнд сурталчилна;

2.2.2. “Монгол үндэстэн” брэндийг тодорхойлж, үндэсний онцлогтой бараа бүтээгдэхүүн, оюуны болон дижитал бүтээлийг олон улсын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ;

2.2.3. Монгол судлалын хүрээг тэлнэ, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаална;

2.2.4. Хилийн чанадад Монголын соёл, мэдээллийн төв байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ;

2.2.5. Монгол Улсын хөгжлийн ололт амжилт, мега төсөл, хөтөлбөрийг хилийн чанадад танилцуулж, хөрөнгө оруулагч, хамтран хэрэгжүүлэгч олоход дэмжлэг үзүүлнэ;

2.2.6. Худалдаа, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжинэ.

Гурав. Баримтлах зарчим

3.1. Цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичиг болон Монгол Улсын олон улсын гэрээнд тусгагдсан зарчимд нийцсэн байх;

3.1.2. үндэсний эв нэгдлийг хангах, ардчилсан ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, тэгш байдал, ил тод байдал, хууль дээдлэх зарчимд нийцсэн байх;

3.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн харилцан уялдаатай хамтын ажиллагаа, оролцоог хангасан байх;

3.1.4. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй, хэмнэлттэй, ил тод, нээлттэй зохион байгуулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

4.1. Цогц арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Монгол үндэстний үнэт зүйлс, Монгол Улсын түүх, биет болон биет бус соёлын өв, уламжлалт болон орчин үеийн соёл, урлаг, оюуны болон дижитал бүтээл, спортын амжилтыг дэлхийн хэмжээнд сурталчлах зорилтын хүрээнд:

5.1.1. үндэсний түүх, хэл бичиг, өв уламжлал, соёл урлаг, шашин, гүн ухаан, оюуны хөгжлийн амжилт бүтээлээ хилийн чанадад таниулан сурталчлах арга хэмжээг дангаар болон хамтран хэрэгжүүлнэ;

5.1.2. олон улсын хэмжээний онцгой үйл явдал, олимп, тэмдэглэлт ой, дипломат харилцааны тэгш ойн хүрээнд тусгай хөтөлбөрийн дагуу үзэсгэлэн гаргаж, соёл урлагийн тоглолт, бэсрэг наадам, өдөрлөг зэрэг хамтарсан арга хэмжээ зохион байгуулна;

5.1.3. олон улсын өндөр зэрэглэлийн соёл, урлаг, спортын наадам, чуулган, үзэсгэлэн яармаг, уралдаан, тэмцээнд оролцоно.

5.2. “Монгол үндэстэн” брэндийг тодорхойлж, үндэсний онцлогтой бараа бүтээгдэхүүн, оюуны болон дижитал бүтээлийг сурталчилж, олон улсын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. “Монгол үндэстэн” брэндийг тодорхойлж хөгжүүлэх, сурталчлах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулж гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллана, мөн хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газар (цаашид “ДТГ” гэх) -аар олон улсад сурталчилна;

5.2.2. Монголд элэгтэй, соёлын харилцаа хөгжүүлэх эрмэлзэлтэй, нэр хүндтэй гадаадын болон монгол иргэнийг Монгол Улсын соёлын элчээр томилон ажиллуулж, соёлын элчийн үйл ажиллагааг бэхжүүлнэ, Монгол Улсыг хилийн чанадад сурталчлах үйл ажиллагаанд соёлын элч нарыг оролцуулна;

5.2.3. Монгол соёл, уламжлал, онцлогийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Мөсний баяр, Адууны баяр” зэрэг арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

5.3. Монгол судлалын хүрээг тэлнэ, дэлхийд тархсан монгол өв, дурсгалыг хамгаалах зорилтын хүрээнд:

5.3.1. Монгол судлалыг хөгжүүлж, хүрээг тэлэх зорилгоор бүсийн болон олон улсын хурал, семинар зохион байгуулж, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг түгээж сурталчилна, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ;

5.3.2. хилийн чанад дахь монгол судлалын төвүүдэд монгол хэл бичиг, түүхийн багш мэргэжилтнүүдийг илгээн ажиллуулна;

5.3.3. Монгол судлаач эрдэмтдийн залуу халааг бэлтгэх, тоог нэмэгдүүлэх зорилгоор тэдэнд зориулсан зуны сургалт, судалгааны аялал зохион байгуулна, судалгааны ажил, эрдмийн бүтээлийг нь олон улсад нийтэлж түгээхэд дэмжлэг үзүүлнэ.

5.4. Хилийн чанадад Монголын соёл, мэдээллийн төв байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих зорилтын хүрээнд:

5.4.1. Монголын худалдаа, эдийн засаг, соёл, мэдээллийн төв байгуулж, мэдээлэл, сурталчилгааны материал, аудио, видео, дижитал бүтээгдэхүүнээр хангана;

5.4.2. Монголын төрт ёсны түүх, өв соёл, нүүдлийн болон орчин үеийн соёл иргэншил, хөгжил, дэвшлийг харуулсан түүхэн эх сурвалж, археологи, палентеологийн олдвор, дурсгал, эд өлгийн зүйлс бүхий үзмэртэй үндэсний хөдөлгөөнт үзэсгэлэн байгуулж дэлхийд аялан толилуулна;

5.4.3. хилийн чанадад хадгалагдаж буй монголын түүхийн өв санд хамаарах эх сурвалж, хөшөө дурсгал, барилга байгууламж, эд өлгийн зүйлсийг судлан тогтоож, бүртгэлжүүлж, хамгаалалтад оролцож, шаардлагатай тохиолдолд хуулбарлан авна.

5.5. Монгол Улсын хөгжлийн ололт амжилт, мега төсөл, хөтөлбөрийг хилийн чанадад танилцуулж, хөрөнгө оруулагч, хамтран хэрэгжүүлэгч олоход дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

5.5.1. олон улсын хэвлэл мэдээллийн томоохон агентлаг, судалгааны байгууллага, хүрээлэнтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ.

5.6. Худалдаа, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд:

5.6.1. дэлхийн болон бүс нутгийн худалдаа, эдийн засгийн томоохон форум, хурал, үзэсгэлэн яармагийн үеэр үндэсний онцлогтой бараа бүтээгдэхүүн сурталчилж, экспортыг дэмжих, мөн хөрөнгө оруулалт татахад туслалцаа үзүүлнэ;

5.6.2. олон улсын аялал жуулчлалын төрөлжсөн үзэсгэлэн яармагт тогтмол оролцож, мэдээлэл, сурталчилгааны тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ;

5.6.3. соёлын өвийн сэргээн засварлагч бэлтгэх, соёл, урлагийн салбарын нарийн мэргэжилтэн дадлагажуулах, соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ, зурмал кино /анимэйшн/, дижитал болон дэлгэцийн урлагийн салбарт шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт

6.1. Цогц арга хэмжээг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана. Зөвлөлийн дарга нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Зөвлөлийн даргын тушаалаар батална. Зөвлөлийн бүрэлдэхүүнд гадаад харилцаа, боловсрол, шинжлэх ухаан, соёл, спорт, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хууль зүй, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

6.3. Зөвлөл нь Цогц арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.

6.4. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг Зөвлөл хариуцан зохион байгуулж, явц, үр дүнг Засгийн газарт жил тутам танилцуулна.

6.5. Зөвлөл нь цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох судалгаа, тайлан гаргах, нийтэд таниулан сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих цахим мэдээллийн системийг хариуцан ажиллуулна.

Долоо. Санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Цогц арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. шаардагдах хөрөнгийн 60 хувийг улсын төсвөөс;

7.1.2. шаардагдах хөрөнгийн 40 хувийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хандив, тусламжаас.

7.2. Улсын төсвөөс шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулна.

Найм. Шалгуур үзүүлэлт

8.1. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

8.1.1 Монгол Улсын гадаад нэр хүнд, монгол үндэстний үнэлэмж дээшилсэн байдал;

8.1.2 хилийн чанадад зохион байгуулсан болон оролцсон соёл, урлагийн арга хэмжээ, үзэсгэлэнгийн тоо, тэдгээрт оролцсон, үзэж сонирхсон иргэдийн тоо;

8.1.3 монгол судлалын хурал, арга хэмжээ, төвүүд, судлаачдын тоо;

8.1.4 Монголын соёл, мэдээллийн төвийн тоо, тэдгээрт хандсан иргэдийн тоо;

8.1.5 гадаадаас ирсэн жуулчдын тоо;

8.1.6 сурталчилсан брэндийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо;

8.1.7 оролцсон спорт, урлагийн наадам, уралдаан, тэмцээний тоо.

8.2. Зөвлөл шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

Ес. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтот үзүүлэлтээр үнэлнэ.

9.2. Цогц арга хэмжээний хэрэгжилтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-oo0oo-